



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 11445

Чингис хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5а, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад дурьдсан нэр бүхий Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2020 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр дуусч байгаа тул боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан сунгасугай.

2.Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн захирал нарт, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт таеьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



202012567

Аймгийн Засаг даргын 2020 оны  
сарын 21-ны өдрийн 3630 дугаар  
захирамжийн хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрлийн  
хугацаа сунгасан байдал

№	Сургалтын байгууллагын нэр	Зөвшөөрөл сунгасан он сар өдөр	Зөвшөөрлийн дуусах хугацаа	Бүртгэлийн дугаар	Гэрчилгээний дугаар
1	Баян-Овоо	9/23/2020	9/19/2029	6	3635
2	Цэнхэрмандал	9/23/2020	9/19/2029	14	3643
3	Дэлгэрхаан	9/23/2020	9/19/2029	9	3638
4	Баянхутаг	9/23/2020	9/19/2029	2	566
5	Баянмөнх	9/23/2020	9/19/2029	5	3634
6	Баян-Адарга	9/23/2020	9/19/2029	4	3633
7	Батширээт	9/23/2020	9/19/2029	3	3632
8	Галшар	9/23/2020	9/19/2029	7	3636
9	Гурванбаян	9/23/2020	9/19/2029	15	3644
10	Дархан	9/23/2020	9/19/2029	8	3637
11	Мөрөн	9/23/2020	9/19/2029	13	3642
12	Жаргалтхаан	9/23/2020	9/19/2029	11	3640
13	Их Ирээдүй	9/23/2020	9/19/2025		571
14	Дадал	9/26/2020	9/26/2031	1	3630